ДУНДГОВЬ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС




# ДУНДГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

**2023 | XII**

ГАРЧИГ

Нийгмийн үзүүлэлт:

I. Ажлын байрны зуучлал....3
II. Бүртгэлтэй ажил хайгч иргэд....3
III. Нийгмийн даатгал....4
IV. Эрүүл мэнд....5
V. Гэмт хэрэг....6
VI. Гамшиг ослын мэдээ....7

Эдийн засгийн үзүүлэлт:

I. Мөнгө, банк....8
II. Төсөв....9
III. Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ....10
IV. Хөдөө аж ахуй....11
V. Аж үйлдвэр....11

Хавсралт хүснэгтүүд

ТАНИЛЦУУЛГА БЭЛТГЭСЭН СТАТИСТИКЧ

Нийгмийн үзүүлэлт:

| | | |
|---|---|---|
| I. | Ажлын байрны зуучлал | С.Доржханд |
| II. | Бүртгэлтэй ажил хайгч иргэд | С.Доржханд |
| III. | Нийгмийн даатгал | Н.Даваанyam |
| IV. | Эрүүл мэнд | Н.Даваанyam |
| V. | Гэмт хэрэг | Г.Ариунжаргал |
| VI. | Гамшиг ослын мэдээ | Н.Даваанyam |

Эдийн засгийн үзүүлэлт:

| | | |
|---|---|---|
| I. | Мөнгө, банк | Т.Бямбасүрэн |
| II. | Төсөв | Т.Бямбасүрэн |
| III. | Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ | Г.Ариунжаргал |
| IV. | Хөдөө аж ахуй | Н.Даваанyam |
| V. | Аж үйлдвэр | Т.Бямбасүрэн |

## Шинэ ажлын байранд 1488 хүн зуучлагджээ

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2023 оны 12 сарын мэдээгээр 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 1488 хүн ажлын байранд зуучлагджээ. Энэ нь өмнөх оноос 695 хүнээр өсжээ. Ажлын байранд зуучлагдсан иргэдийн 734 буюу 49.3 хувь нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 1. АЖИЛД ЗУУЧИЛСАН ИРГЭДИЙН ТОО, жил бүрийн эцсийн байдлаар




Ажлын байранд зуучлагдсан иргэдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд ХАА-ын салбарт 33.9 хувь, боловсролын салбарт 6.1 хувь, уул уурхай олборлох үйлдвэрийн салбарт 2.9 хувь, төрийн удирдлагын салбарт тус бүр 11.2 хувь, боловсруулах аж үйлдвэрийн салбарт 9.1 хувь, бөөний болон жижиглэн худалдааны салбарт 6.1 хувь, бусад салбарт 29.0 хувь нь зуучлагджээ.

ЗУРАГ 2. АЖЛЫН БАЙРНЫ ЗУУЧЛАЛ, эдийн засгийн салбараар, хувиар



## Бүртгэлтэй ажил хайгч 389 иргэн байна

2023 оны жилийн эцсийн байдлаар аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгэлтэй, ажил хайж байгаа 389 хүн бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 2 дахин өссөн байна. Нийт бүртгэлтэй ажил хайгч иргэдийн 55.6 хувь буюу 220 нь эмэгтэйчүүд байна. Тус аймгийн хувьд 10000 хүнд ногдох бүртгэлтэй ажил хайгч иргэдийн тоо 119 байна.

ЗУРАГ 3. АЖИЛ ХАЙГЧ ИРГЭД, үүнээс эмэгтэй, жил бүрийн эцсийн байдлаар




## Нийгмийн даатгалын сангийн орлого 4.9 тэрбумаар өссөн байна

Аймгийн нийгмийн даатгалын сангийн орлого 2023 оны жилийн эцсийн байдлаар 66.8 тэрбум төгрөг, зарлага 66.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 4.9 тэрбум төгрөгөөр буюу 7.9 хувиар, зарлага 7.3 тэрбум төгрөг буюу 12.3 хувиар тус тус өссөн байна.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээгээр нийгмийн даатгалд 2023 оны жилийн эцсийн байдлаар 10351 хүн шимтгэл төлөгч, даатгуулагчаар бүртгэгдсэний 2745 хүн буюу 26.5 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагаас, 4160 хүн буюу 40.2 хувь нь төсөвт байгууллагаас, 3446 хүн буюу 33.3 хувь нь сайн дураар шимтгэл төлсөн нь өмнөх онтой харьцуулахад аж ахуйн нэгж байгууллагын даатгуулагч өсч, төсөвт байгууллагын даатгуулагч, сайн дурын даатгуулагч тус тус буурсан байна.

ЗУРАГ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ /хувиар/




ЗУРАГ 5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨГЧ /хувиар/




Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ 2023 оны жилийн эцсийн байдлаар 58.3 тэрбум төгрөг болж, үүний 86.5 хувийг өндөр настны, 7.6 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 2.2 хувийг тэжээгчээ алдсаны, 3.6 хувийг цэргийн тэтгэвэр эзэлж байна.

Энэ оны жилийн эцсийн байдлаар тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч хүн 8414 байна. Нийт тэтгэвэр авагчдын 85.8 хувь буюу 7219 хүн өндөр насны, 9.6 хувь буюу 804 хүн тахир дутуугийн, 2.7 хувь буюу 227 хүн тэжээгчээ алдсаны, 1.9 хувь буюу 164 хүн нь цэргийн тэтгэвэр авагчид байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авагчид 2001, ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авагчид 17, ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж авагч 261 хүн байна.

Тухайн оны жилийн эцсийн байдлаар эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн тоо 13567 байгаагийн 55.2 хувь буюу 7483 төр хариуцах иргэд, 32.7 хувь буюу 4433 малчид, 1.3 хувь буюу 181 оюутан суралцагсад, 10.8 хувь нь буюу 1470 аж ахуйн нэгжийн эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн байна.

## Төрөлт өмнөх оны мөн үеэс 1.9 хувиар өссөн байна



Эрүүл мэндийн газрын мэдээгээр аймгийн хэмжээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар 689 эх төрсөн ба нийт 689 хүүхэд амьд төрсөн нь өмнөх оноос 1.9 хувиар буюу 13 төрөлтөөр өссөн үзүүлэлт байна. Төрсөн эхчүүдийн 94.9 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт төржээ. Тус аймагт энэ оны жилийн эцсийн байдлаар 0-1 насны хүүхдийн эндэгдэл 7, 0-5 насны хүүхдийн эндэгдэл 10 бүртгэгдсэн байна. Нас баралтын 224 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд өмнөх оноос 13 тохиолдлоор буурсан. Нас баралтыг шалтгаанаар нь авч үзвэл хорт хавдрын нас баралт 67 буюу 29.9 хувийг эзэлж байна.

Тухайн жилийн эцсийн байдлаар стационарит шинээр 10351 эмчлүүлэгч хэвтэж, 10255 эмчлүүлэгч эмнэлгээс гарсан бөгөөд нийт 75053 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 7.3 байна.

ЗУРАГ 6. ТӨРСӨН ХҮҮХДИЙН ТОО




ЗУРАГ 7. ЭМЧЛЭГДЭЖ ГАРСАН ХҮНИЙ ТОО




2023 оны жилийн эцсийн байдлаар 177548 амбулаторийн үзлэг бүртгэгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 23.6 хувь, өвчний учир амбулаторийн үзлэг 62.3 хувь, идэвхтэй хяналт 9.0 хувь, гэрийн идэвхтэй үзлэг 4.0 хувь, гэрийн дуудлагын үзлэг 1.1 хувийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүмүүсийн 35.3 хувь нь эрэгтэй, 64.7 хувь нь эмэгтэй хүн байна

Халдварт өвчний 427 тохиолдол бүртгэгдээд байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 90.1 хувь болж өмнөх оны мөн үеэс 3231 тохиолдол буюу 681.5 хувиар буурсан байна.

## Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 246 болж өмнөх оноос 0.4 хувиар буурчээ

Дундговь аймаг дахь Цагдаагийн газар нь 2023 оны жилийн эцсийн байдлаар иргэн, хуулийн этгээдээс гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 1663 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 72(4.1%)-р буурсан байна.

2023 оны жилийн эцэст улсын хэмжээнд 35574 гэмт хэрэг бүртгэгдсэний 246 буюу 0.7 хувь нь Дундговь аймагт бүртгэгдсэн гэмт хэрэг байна. Энэ нь өмнөх оноос 1 хэргээр буюу 0.4 хувиар буурсан үзүүлэлт байна.

ЗУРАГ 8. 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭСТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ / Өмнөх 2 онтой харьцуулснаар/



Бүртгэгдсэн нийт 246 гэмт хэргийг өмнөх онтой харьцуулахад хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 20(20.6%) хэргээр, дээрэмдэх гэмт хэрэг 1(50%) хэргээр, залилах гэмт хэрэг 4(14.3%) хэргээр, хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх хэрэг 2(2 дахин) хэргээр, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 10(55.5%) хэргээр, хулгайлах гэмт хэрэг 1(2.6%) хэргээр өссөн бол хүчиндэх гэмт хэрэг 7(70.0%) хэргээр, мал хулгайлах гэмт хэрэг 7(77.7%) хэргээр, хүнийг санаатай алах гэмт хэрэг 6(85.7%) хэргээр, бусад гэмт хэрэг 12(40.0%) хэргээр, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 7(7 дахин) хэргээр буурсан байна.

Гэмт хэргийн улмаас 13 хүн нас барж, 256 иргэн хохирч, 141 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал гэмт хэргийн улмаас гэмтсэн хүний тоо 24(20.5%) хүнээр өссөн бол нас барсан хүний тоо 1(8.3%) хүнээр, хохирсон хүний тоо 10(3.7%) хүнээр буурсан байна.

Гэмт хэрэгт нийт 197 хүн холбогдон шалгагдсан нь өмнөх онтой ижил байна.
Нийт гэмт хэргийн 83(33.7%) нь согтуугаар, 27(10.9%) нь эмэгтэй хүн оролцсон, 7(2.8%) нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн, 6(2.4%) нь хүүхэд оролцсон, цахим орчинд үйлдэгдсэн 20(8.1%), бүлэглэн гүйцэтгэсэн 6(2.4) гэмт хэрэг байна.

ЗУРАГ 9. ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН БАЙДЛААР, нийт гэмт хэрэгт эзлэх хувиар




Аймгийн хэмжээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар 22097 зөрчил шалгасан нь өмнөх оноос 1079(5.1%) зөрчлөөр буурсан үзүүлэлттэй байна. Зөрчил гаргасан 21507 иргэнийг 966.4 сая төгрөгөөр торгосон байна. Үүнээс тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэргээр 344 хүнийг торгон, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нь хасаж, 209 хүнд баривчлах, 79 хүнд саатуулах шийтгэл тус тус ногдуулсан байна.
Нийт 53 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 234 (4.4 дахин) хүнээр буурсан байна.

## Зам тээврийн осол 7 тохиолдол бүртгэгдсэн байна

Аймгийн Онцгой байдлын газраас ирсэн мэдээгээр 2023 оны жилийн эцсийн байдлаар аюулт үзэгдэл, ослын 119 дуудлага бүртгэгдсэн байна.  Үүнээс объектийн гал түймрийн дуудлага 26 удаа бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад гал түймрийн тоо өссөн үзүүлэлттэй байна. Мөн зам тээврийн осол 7, төөрсөн сураггүй болсон, цасанд суусан дуудлага 23, хүчтэй салхи шуурганы 30, малын гоц халдварт өвчний 24 удаагийн дуудлага бүртгэгджээ. Нийт нутгаар цас орж, цасан бүрхүүл тогтсонтой холбоотой автомашинтай цасанд суусан, төөрсөн, сураггүй болосон дуудлага эрс нэмэгдэж байгаад анхаарах шаардлагатай байна.

## Нийт хадгаламжийн үлдэгдэл өмнөх оноос 12.9 хувиар өсжээ

Тус аймагт нийт 34 банкны салбар нэгжид 166 хүн  ажиллаж байна. Банкны зээлийн үлдэгдэл өмнөх оноос 25.8 хувиар өсч, 171.3 тэрбум төгрөг болжээ. Үүнээс анхаарал хандуулах зээл 1.3 тэрбум төгрөг, чанаргүй зээл 1.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй болж өмнөх оноос анхаарал хандуулах зээл 23.9 хувиар буурч, чанаргүй зээл  12.0 хувиар өссөн байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 1.7 хувийг анхаарал хандуулах ба чанаргүй зээл эзэлж байна. Нийт хадгаламжийн үлдэгдэл  өмнөх оноос  12.9 хувиар өсч, 93.0 тэрбум төгрөг  болжээ.

ЗУРАГ 10. БАНКНЫ ХАДГАЛАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ, ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, тэрбум төгрөгөөр




ЗУРАГ 11. БАНКНЫ ХАДГАЛАМЖ ЭЗЭМШИГЧ, ЗЭЭЛДЭГЧИЙН ТОО, мянган хүн, дансны тоогоор




## Улсын төвлөрсөн төсөвт оруулбал зохих орлогын төлөвлөгөө 140.6 хувьтай байна

Санхүү, төрийн сангийн хэлтэс болон Татварын хэлтсийн мэдээгээр 2023 оны жилийн эцсийн байдлаар орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөний биелэлт 140.3 хувьтай буюу 16.3 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Мөн улсын төвлөрсөн төсөвт оруулбал зохих орлогын төлөвлөгөө 140.6 хувьтай буюу 3.1 тэрбум төгрөгийн орлогыг улсын төвлөрсөн төсөвт оруулаад байна.

Тусламжийн орлогыг оруулан тооцсоноор аймгийн хэмжээний нийт орлого ба тусламж 99.9 тэрбум төгрөг болж, төлөвлөгөөний биелэлт 96.9 хувьтай байна.

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг Дэрэн, Говь-Угтаал, Өндөршил, Дэлгэрхангай Эрдэнэдалай сумд 2.0-16.8 хувиар тасалдуулсан бол бусад сумд 5.1-148.0 хувиар буюу 18.3 сая төгрөгөөс 7.6 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

ЗУРАГ 12. ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН БҮТЭЦ, хувиар




2023 оны жилийн эцсийн байдлаар орон нутгийн төсвийн байгууллагын зарлагын нийт дүн 54.4 тэрбум төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 32.7 хувиар өссөн байна. Зардлын төрлөөр авч үзвэл цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оны мөн үеэс 25.5 хувиар өсч, 8.3

тэрбум төгрөг болсон нь нийт зардлын 15.3 хувийг эзэлж байна. Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл өмнөх оны мөн үеэс 26.2 хувиар өсч, 1.0 тэрбум төгрөг болсон байна.

Тухайн оны жилийн эцсийн байдлаар өмнөх онтой харьцуулбал бусад урсгал шилжүүлэг 33.0, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 19.4 хувиар тус тус буурсан бол бусад зардал 15.8 хувиас 11.8 дахин өссөн байна.

## Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн индекс өмнөх оноос 6.1 хувиар өсжээ

Хэрэглээний үнийн индекс нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нэг өрхөөр биш, нийт өрхөөр тооцсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна. Тус аймагт 2023 оны жилийн эцсийн байдлаар хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх онтой харьцуулахад 6.1 хувиар өсжээ.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 6.1 хувиар өсөхөд хүнсний бараа согтууруулах бус ундааны бүлгийн үнэ дүнгээрээ 15.3 хувиар, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис дүнгээрээ 5.8 хувиар, хувцас бөс бараа гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 4.6 хувиар, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш бүлгийн үнэ дүнгээрээ 0.9 хувиар, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ дүнгээрээ 5.8 хувиар, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлэг дүнгээрээ 7.7 хувиар, амралт чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 9.6 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

ЗУРАГ 13. ДУНДГОВЬ АЙМГИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС /Өмнөх оны мөн үетэй харьцуулснаар/




2023 оны 12 сарын байдлаар Сайнцагаан сумын хүнсний зах, дэлгүүрт худалдаалагдаж байгаа хүнсний гол нэрийн бараа, бензин, дизель түлшний үнийг орууллаа.

ХҮСНЭГТ 1. ХҮНСНИЙ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ /7 хоногоор/

| № | Барааны нэр, төрөл | XII/04 | XII/11 | XII/18 | XII/25 |
|---|---|---|---|---|---|
| 1 | Гурил, 1-р зэрэг, кг | 2 882 | 2 882 | 2 882 | 2 882 |
| 2 | Хонины мах, кг | 7 500 | 8 500 | 8 500 | 8 500 |
| 3 | Үхрийн мах, кг | 12 490 | 13 000 | 13 000 | 13 000 |
| 4 | Ямааны ястай мах, кг | 6 500 | 7 500 | 7 500 | 7 500 |
| 5 | Элсэн чихэр, кг | 4 962 | 4 962 | 4 589 | 4 589 |
| 6 | Цагаан будаа, кг | 3 953 | 3 962 | 3 962 | 3 962 |
| 7 | Шингэн сүү, л | 5 000 | 5 000 | 6 000 | 6 000 |
| 8 | Ноолуурын үнэ 1 кг | 90 000 | 90 000 | 90 000 | 90 000 |
| 9 | Бензин А-80, 1литр | 2 510 | 2 510 | 2 510 | 0 |
| 10 | Бензин А-92, 1литр | 2 530 | 2 530 | 2 530 | 2 530 |
| 11 | Дизель түлш 1 литр | 4 000 | 4 000 | 4 000 | 4 000 |
| 12 | Боодолтой өвс 1 ш | 15 000 | 15 000 | 15 000 | 20 000 |

## Мал тооллогын урьдчилсан дүнгээр Дундговь аймгийн малын тоо өмнөх оноос 33.7 мянган толгойгоор өслөө

Дундговь аймаг 2023 оны жилийн эцсийн мал тооллогын урьдчилсан дүнгээр 3660.1 мянган толгой мал тоолуулсан нь өмнөх оноос 33.7 мянган толгой буюу 0.9 хувиар өссөн байна. Үүний дотор адуу 194.6, үхэр 85.5, тэмээ 43.7, хонь 1759.4, ямаа 1576.9 мянган толгой болж, адуу, үхэр, тэмээ, хонь өссөн байна. Улсын хэмжээнд тэмээний тоогоор 5-р байр, нийт малын тоогоор Эрдэнэдалай сум 2-р байранд орлоо. Эрдэнэдалай сум нь 2017 онд 550.6 мянган толгой мал тоолуулж Улсын хэмжээнд хамгийн олон мал тоолуулж байсан бол 2018, 2019 онуудад Малын тоогоор мөн 2-т эрэмбэлэгдэж байсан байна.

ЗУРАГ 14. ДУНДГОВЬ АЙМГИЙН МАЛЫН ТОО, мянган толгойгоор, онуудаар




Нийт мал сүрэгт хонь 47.5 хувь, ямаа 44.2 хувь, адуу 5.0 хувь, үхэр 2.1 хувь, тэмээ 1.1 хувийг эзэлж байна. Энэ оныг 1980 онтой харьцуулж үзэхэд нийт сүрэгт ямааны эзлэх хувь 19.5 нэгж хувиар өссөн, хонины эзлэх хувь 6.8 нэгж хувиар, адууны эзлэх хувь 5.6 нэгж хувиар, үхрийн эзлэх хувь 4.2 нэгж хувиар, тэмээний эзлэх хувь 3.0 нэгж хувиар тус тус буурсан байна.

ЗУРАГ 15. МАЛ СҮРГИЙН БҮТЭЦ, хувиар, онуудаар




Эрдэнэдалай сум 550.6 мянган толгой, Сайнцагаан сум 376.2 мянган толгой, Өлзийт сум 305.5 мянган толгой, Адаацаг сум 295.5 мянган толгой, Хулд сум 269.5 мянган толгой мал тоолуулсан байна.

ЗУРАГ 16. МАЛЧДЫН СОЁЛЫН ҮЗҮҮЛЭЛТ 2023, насаар




2023 оны жилийн эцсийн байдлаар 11694 малчин байна. Нийт малчдын 60.2 хувь нь зээлтэй ба зээл авсан малчдын 18 хувийг 24 хүртэлх насны, 31 хувийг 35-44 насны, 29 хувийг 45-54 насны малчид эзэлж байна. Мөн малчдын 54.9 хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан бол 35.3 хувь нь нийгмийн даатгалд хамрагдсан байна.



## Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2023 оны жилийн эцсийн байдлаар 55.8 тэрбум төгрөгт хүрчээ

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2023 оны жилийн эцсийн байдлаар 55.8 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 67.3 хувиар өссөн байна. Энэхүү өсөлтөд уул уурхай олборлох үйлдвэрлэл 78.8 дахин өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ХАВСРАЛТ ХҮСНЭГТҮҮД

## I. АЖЛЫН БАЙРНЫ ЗУУЧЛАЛ, 2023 оны 12 сарын байдлаар

| Эдийн засгийн салбарын ангилал | Ажилд зуучилсан иргэд | үүнээс: эмэгтэй | Эдийн засгийн салбарын эзлэх хувь |
|---|---|---|---|
| **Бүгд** | **1488** | **734** | **100.0** |
| ХАА, ан агнуур, ойн аж ахуй | 504 | 246 | 33.9 |
| Уул уурхай олборлох үйлдвэр | 43 | 8 | 2.9 |
| Боловсруулах аж үйлдвэр | 135 | 54 | 9.1 |
| Цахилгаан эрчим хүч, хий, уур агааржуулалт | 5 | 2 | 0.3 |
| Усан хангамж, бохир ус, зайлуулах систем, хог | 86 | 24 | 5.8 |
| Барилга | 54 | 13 | 3.6 |
| Бөөний ба жижиглэн худалдаа | 91 | 53 | 6.1 |
| Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа | 1 | 1 | 0.1 |
| Зочид буудал, зоогийн газар | 12 | 11 | 0.8 |
| Мэдээлэл холбоо | 8 | 4 | 0.5 |
| Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа | 9 | 3 | 0.6 |
| Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа | 0 | 0 | 0.0 |
| Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа | 8 | 4 | 0.5 |
| Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа | 132 | 66 | 8.9 |
| Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа | 167 | 87 | 11.2 |
| Боловсрол | 91 | 64 | 6.1 |
| Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа | 45 | 36 | 3.0 |
| Урлаг, үзвэр, тоглоом наадам | 3 | 2 | 0.2 |
| Үйлчилгээний бусад үйл ажиллагаа | 92 | 54 | 6.2 |
| Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа | 2 | 2 | 0.1 |
| Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа | 0 | 0 | 0.0 |

## II. АЙМГИЙН АЖИЛ ХАЙГЧ ИРГЭДИЙН МЭДЭЭ

| Сум | Оны эхний хөдөлмөрийн насны хүн ам | Тайлант сарын эхэнд байсан ажил хайгч иргэд | Тайлант сарын эцэст байгаа ажил хайгч иргэд | Үүнээс эмэгтэй | Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажил хайгч |
|---|---|---|---|---|---|
| **Дүн** | **32 721** | **121** | **389** | **220** | **119** |
| Сайнцагаан | 11 073 | 80 | 121 | 71 | 109 |
| Адаацаг | 1 910 | 1 | 0 | 0 | 0 |
| Баянжаргалан | 879 | 0 | 0 | 0 | 0 |
| Говь-Угтаал | 1 060 | 0 | 1 | 1 | 9 |
| Гурвансайхан | 1 548 | 1 | 6 | 3 | 39 |
| Дэлгэрхангай | 1 550 | 5 | 148 | 94 | 955 |
| Дэлгэрцогт | 1 136 | 2 | 23 | 9 | 202 |
| Дэрэн | 1 494 | 12 | 22 | 15 | 147 |
| Луус | 1 385 | 4 | 10 | 4 | 72 |
| Өлзийт | 1 704 | 3 | 5 | 1 | 29 |
| Өндөршил | 1 038 | 1 | 20 | 11 | 193 |
| Сайхан-Овоо | 1 524 | 0 | 0 | 0 | 0 |
| Хулд | 1 704 | 2 | 11 | 4 | 65 |
| Цагаандэлгэр | 701 | 0 | 0 | 0 | 0 |
| Эрдэнэдалай | 4 015 | 10 | 22 | 7 | 55 |

## III. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО, ТЭТГЭВЭРИЙН САНХҮҮЖИЛТ

2023 оны жилийн эцсийн байдлаар, мян. төг

| Сумд | Н.Д.Шимтгэлийн орлого | | | Тэтгэврийн санхүүжилт | | |
|---|---|---|---|---|---|---|
| | төл | гүйц | хувь | олгох | олгосон | хувь |
| **Дүн** | **22676003.5** | **23880065.4** | **105.3** | **58468345.9** | **58468345.9** | **100.0** |
| Дэлгэрцогт | 520214.4 | 520301.4 | 100.0 | 2193546.6 | 2193546.6 | 100.0 |
| Дэрэн | 544743.1 | 546831.8 | 100.4 | 2547402.4 | 2547402.4 | 100.0 |
| Говь-Угтаал | 773188.3 | 773517.1 | 100.0 | 2059589.5 | 2059589.5 | 100.0 |
| Цагаандэлгэр | 355901.0 | 356519.0 | 100.2 | 1183433.6 | 1183433.6 | 100.0 |
| Баянжаргалан | 591001.3 | 592182.0 | 100.2 | 1264338.9 | 1264338.9 | 100.0 |
| Өндөршил | 612054.0 | 615815.3 | 100.6 | 1739165.8 | 1739165.8 | 100.0 |
| Гурвансайхан | 674840.7 | 674953.3 | 100.0 | 2418757.8 | 2418757.8 | 100.0 |
| Өлзийт | 740428.3 | 742372.8 | 100.3 | 2919665.1 | 2919665.1 | 100.0 |
| Хулд | 722859.0 | 725994.2 | 100.4 | 2862402.3 | 2862402.3 | 100.0 |
| Луус | 591086.7 | 596546.4 | 100.9 | 2342837.6 | 2342837.6 | 100.0 |
| Дэлгэрхангай | 805734.7 | 806254.8 | 100.1 | 2708801.0 | 2708801.0 | 100.0 |
| Сайхан-Овоо | 586014.8 | 588456.8 | 100.4 | 2194181.2 | 2194181.2 | 100.0 |
| Эрдэнэдалай | 1494470.9 | 1499691.8 | 100.3 | 6963495.3 | 6963495.3 | 100.0 |
| Адаацаг | 681528.9 | 688732.2 | 101.1 | 3008378.0 | 3008378.0 | 100.0 |
| Сайнцагаан | 12981937.3 | 14151896.5 | 109.0 | 22062351.0 | 22062351.0 | 100.0 |

## IV.НИЙГМИЙН ДААТГАЛЫН ОРЛОГО, ЗАРЛАГА / сая.төг /

| | 2022 XII | 2023 XII | | | 2023 XII / 2022 XII хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | |
| **Нийгмийн даатгалын сангийн орлого** | **61905.4** | **30415.4** | **66784.6** | **219.6** | **107.9** |
| Үүнээс | | | | | |
| Тэтгэврийн даатгалын сангийн | 55338.6 | 26786.9 | 58844.1 | 219.7 | 106.3 |
| Тэтгэмжийн даатгалын сангийн | 2075.0 | 1964.4 | 2435.1 | 124.0 | 117.4 |
| Эрүүл мэндийн даатгалын сангийн | 2909.2 | 0.0 | 3694.8 | 0.0 | 127.0 |
| ҮОМШӨ*-ний даатгалын сангийн | 911.4 | 1305.4 | 1192.6 | 91.4 | 130.9 |
| Ажилгүйдлийн даатгалын сангийн | 671.2 | 358.7 | 618.0 | 172.3 | 92.1 |
| **Нийгмийн даатгалын сангийн зарлага** | **59384.5** | **64768.7** | **66736.5** | **103.0** | **112.4** |
| Үүнээс | | | | | |
| Тэтгэврийн даатгалын сангийн | 53390.0 | 60656.8 | 58610.9 | 96.6 | 109.8 |
| Тэтгэмжийн даатгалын сангийн | 1983.8 | 2963.3 | 2513.1 | 84.8 | 126.7 |
| Эрүүл мэндийн даатгалын сангийн | 2559.0 | 0.0 | 3694.2 | 0.0 | 144.4 |
| ҮОМШӨ*-ний даатгалын сангийн | 829.7 | 472.8 | 1273.6 | 269.4 | 153.5 |
| Ажилгүйдлийн даатгалын сангийн | 622.0 | 675.9 | 644.8 | 95.4 | 103.7 |

Тайлбар: *Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал

## V.НИЙГМИЙН ДААТГАЛД ЗААВАЛ ДААТГУУЛАГЧИЙН ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВЭРИЙН ХЭМЖЭЭ

| Үзүүлэлтүүд | | 2021 XII | 2022 XII | 2023 XII | 2023 XII / 2022 XII хувь |
|---|---|---|---|---|---|
| **Заавал даатгуулагчийн тоо** | | **10877** | **10667** | **10351** | **97.0** |
| Үүнээс | | | | | |
| | Аж ахуй нэгж, байгууллага | 2509 | 2499 | 2745 | 109.8 |
| | Төсөвт байгууллага | 4271 | 4399 | 4160 | 94.6 |
| | Сайн дурын | 4097 | 3769 | 3446 | 91.4 |
| **Олгосон тэтгэвэр,** | | **37234.8** | **50228.6** | **58345.9** | **116.2** |
| Үүнээс | | | | | |
| | Өндөр настны | 31770.5 | 43200.1 | 50489.0 | 116.9 |
| | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн | 3329.0 | 4289.4 | 4436.5 | 103.4 |
| | Тэжээгчээ алдсаны | 941.8 | 1236.8 | 1296.0 | 104.8 |
| | Цэргийн | 1193.5 | 1502.3 | 2124.4 | 141.4 |

## VI. ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨН ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ сумдаар

| сумд | төрсөн хүүхдийн тоо | | Бүх нас баралт | | 0-1 насны хүүхдийн эндэгдэл | | 0-5 насны хүүхдийн эндэгдэл | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2022 | 2023 | 2022 | 2023 | 2022 | 2023 | 2022 | 2023 |
| **Дүн** | **676** | **692** | **237** | **224** | **8** | **7** | **8** | **10** |
| Сайнцагаан | 641 | 657 | 91 | 102 | 4 | 7 | 4 | 8 |
| Адаацаг | 2 | 1 | 11 | 10 | 0 | 0 | 0 | 0 |
| Баянжаргалан | 2 | 2 | 12 | 13 | 0 | 0 | 0 | 0 |
| Говь-Угтаал | 3 | 4 | 8 | 6 | 0 | 0 | 0 | 0 |
| Гурвансайхан | 3 | 0 | 7 | 6 | 3 | 0 | 3 | 0 |
| Дэлгэрхангай | 7 | 8 | 11 | 8 | 0 | 0 | 0 | 0 |
| Дэлгэрцогт | 0 | 0 | 4 | 9 | 0 | 0 | 0 | 0 |
| Дэрэн | 3 | 1 | 11 | 10 | 0 | 0 | 0 | 1 |
| Луус | 0 | 0 | 3 | 10 | 0 | 0 | 0 | 0 |
| Өлзийт | 3 | 3 | 4 | 7 | 1 | 0 | 1 | 0 |
| Өндөршил | 6 | 2 | 16 | 12 | 0 | 0 | 0 | 0 |
| Сайхан-Овоо | 2 | 2 | 9 | 4 | 0 | 0 | 0 | 0 |
| Хулд | 0 | 2 | 9 | 4 | 0 | 0 | 0 | 0 |
| Цагаандэлгэр | 1 | 2 | 5 | 2 | 0 | 0 | 0 | 0 |
| Эрдэнэдалай | 3 | 8 | 36 | 21 | 0 | 0 | 0 | 1 |

## VII. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жилийн эцсийн байдлаар

| Сумд | Хэвтэж эмчлүүлсэн хүний тоо | | Бүгд үзлэг | | Бүртгэгдсэн бүх өвчлөл | | Халдварт өвчин бүгд | | үүнээс /зарим үзүүлэлтээр/ | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | сүрьеэ | | Салхин цэцэг | |
| | 2022 | 2023 | 2022 | 2023 | 2022 | 2023 | 2022 | 2023 | 2022 | 2023 | 2022 | 2023 |
| **Дүн** | **10574** | **10255** | **159840** | **177548** | **38909** | **52972** | **3658** | **427** | **22** | **10** | **132** | **155** |
| Сц | 5829 | 5511 | 123217 | 137561 | 32067 | 45104 | 1979 | 272 | 10 | 6 | 96 | 104 |
| Ад | 322 | 222 | 2972 | 2994 | 142 | 607 | 232 | 41 | 0 | 2 | 7 | 9 |
| Бж | 238 | 181 | 1379 | 1679 | 120 | 189 | 41 | 2 | 0 | 0 | 4 | 2 |
| Гу | 113 | 203 | 2275 | 2642 | 877 | 1046 | 160 | 9 | 0 | 0 | 0 | 2 |
| Гс | 86 | 121 | 1579 | 2583 | 126 | 322 | 149 | 9 | 0 | 0 | 2 | 5 |
| Дх | 275 | 290 | 1874 | 1982 | 178 | 89 | 141 | 5 | 1 | 1 | 0 | 0 |
| Дц | 267 | 186 | 2304 | 1441 | 277 | 222 | 88 | 8 | 4 | 1 | 0 | 0 |
| Дн | 229 | 172 | 2339 | 2069 | 249 | 259 | 81 | 7 | 2 | 0 | 5 | 1 |
| Лс | 234 | 203 | 3040 | 2629 | 222 | 145 | 87 | 7 | 1 | 0 | 0 | 1 |
| Өт | 138 | 146 | 1428 | 2389 | 38 | 145 | 184 | 37 | 0 | 0 | 0 | 27 |
| Өш | 305 | 280 | 3667 | 2142 | 539 | 473 | 81 | 3 | 0 | 0 | 11 | 0 |
| Со | 99 | 111 | 1003 | 781 | 475 | 290 | 57 | 7 | 0 | 0 | 0 | 2 |
| Хд | 234 | 118 | 1054 | 952 | 485 | 220 | 111 | 7 | 2 | 0 | 7 | 0 |
| Цд | 193 | 177 | 868 | 1004 | 406 | 436 | 75 | 3 | 0 | 0 | 0 | 0 |
| Эд | 308 | 541 | 8126 | 11238 | 2548 | 2893 | 192 | 10 | 2 | 0 | 0 | 2 |
| Мд | 367 | 176 | 396 | 171 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Эб | 429 | 342 | 420 | 337 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| МУЭ төв | 908 | 1275 | 1899 | 2954 | 160 | 532 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |

* Эрүүл мэндийн газрын мэдээгээр

## VIII. ГЭМТ ХЭРГИЙН МЭДЭЭ-1

| Үзүүлэлт | 2022 XII | 2023 XII | 23/22хувь |
|---|---|---|---|
| Оны эхний 18 ба түүнээс дээш насны хүний тоо | 30773 | 30578 | 99.4 |
| Бүх хэрэг | **247** | **246** | **99.6** |
| Хүнийг санаатай алах гэмт хэрэг | 7 | 1 | 14.3 |
| Хүчиндэх гэмт хэрэг | 10 | 3 | 30.0 |
| Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх | 0 | 2 | - |
| Дээрэмдэх гэмт хэрэг | 2 | 3 | 150.0 |
| Хүрээлэн байгаа орчны эсрэг | 7 | 0 | 0.0 |
| Танхайн хэрэг | 0 | 0 | - |
| Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг | 97 | 117 | 120.6 |
| Бусдын эд хөрөнгийн хулгай | 39 | 40 | 102.6 |
| Малын хулгай | 9 | 2 | 22.2 |
| Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэрэг | 18 | 28 | 155.6 |
| Залилангийн хэрэг | 28 | 32 | 114.3 |
| Эдийн засгийн гэмт хэрэг | 0 | 0 | - |
| Бусад | 30 | 18 | 60.0 |
| Эмэгтэй хүн оролцсон | 22 | 27 | 12.0 |
| Согтуугаар | 96 | 83 | 86.5 |
| Бүлэглэж | 16 | 6 | 37.5 |
| Хүүхэд оролцсон | 11 | 6 | 54.5 |
| Гэр бүлийн хүчирхийлллийн улмаас | 23 | 7 | 30.4 |
| Хөнгөн | 188 | 217 | 115.4 |
| Хүнд | 59 | 29 | 49.2 |
| Гэмт хэрэгт холбогдогсод | 197 | 197 | 100.0 |
| Учирсан бүх хохирол /сая.төг/ | 1091.5 | 1057.2 | 96.9 |
| Нөхөн төлүүлсэн хохирол /сая.төг/ | 484.5 | 573.9 | 118.5 |
| Илрүүлэлтийн хувь | 59.4 | 66.9 | 112.6 |
| 18 аас дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /аймаг/ | 80 | 80 | 100.2 |

## IX. ГЭМТ ХЭРГИЙН МЭДЭЭ-2

| № | Үзүүлэлтүүд | 2022 XII | 2023 XII | 2022/2023 хувь |
|---|---|---|---|---|
| 1 | Гэмт хэргийн улмаас: | 129 | 154 | 119.4 |
| | Нас барсан | 12 | 13 | 108.3 |
| | Гэмтсэн | 117 | 141 | 120.5 |
| 2 | Зам тээврийн осолын улмаас: | 15 | 28 | 186.7 |
| | Нас барсан | 3 | 9 | 300.0 |
| | Гэмтсэн | 12 | 19 | 158.3 |
| 3 | Гэмт хэргийн улмаас хохирсон хүний тоо /Үүнээс/ | 266 | 256 | 96.2 |
| | Эмэгтэй | 111 | 87 | 78.4 |
| | 7 хүртэлх насны | 2 | 5 | 250.0 |
| | 8-13 насны | 9 | 4 | 44.4 |
| | 14-17 насны | 16 | 13 | 81.3 |
| 4 | Бүх хүлээн авсан өргөдөл, гомдол мэдээлэл | 1735 | 1663 | 95.9 |
| | Бүх шийдвэрлэсэн гэмт хэргийн шинжтэй ӨГМ | 587 | 635 | 108.2 |
| | Хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн | 227 | 215 | 94.7 |
| | Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан | 328 | 393 | 119.8 |
| | Харьяаллын дагуу шилжүүлсэн | 6 | 8 | 133.3 |
| | Үлдэгдэл | 26 | 19 | 73.1 |
| | Бүх шийдсэнээс 5 хоногт шийдвэрлэсэн | 72 | 83 | 115.3 |
| | 6-ба түүнээс дээш | 489 | 533 | 109.0 |
| 5 | Бүх шийдвэрлэсэн захиргааны зөрчлийн шинжтэй өргөдөл гомдол мэдээлэл /Үүнд/ | 1148 | 1028 | 89.5 |
| | 5 хоногт | 915 | 921 | 100.7 |
| | 6 ба түүнээс дээш | 225 | 90 | 40.0 |
| | Үлдэгдэл | 8 | 17 | 212.5 |
| 6 | Нийт зөрчил | 21018 | 22097 | 105.1 |
| 7 | Илрүүлсэн зөрчил | | | |
| | ЗЦТасгаас илрүүлсэн | 15068 | 15692 | 104.1 |
| | НХЖХТасгаас илрүүлсэн | 5950 | 6405 | 107.6 |
| 8 | Тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасч, торгосон | 397 | 344 | 86.6 |
| 9 | Баривчлагдсан хүн | 177 | 209 | 118.1 |
| 10 | Журамласан тээврийн хэрэгсэл | 518 | 415 | 80.1 |
| 11 | Эрүүлжүүлэгдсэн хүн | 234 | 53 | 22.6 |
| 12 | Саатуулагдсан хүн | | 79 | - |
| 13 | Зөрчлийн хуулиар арга хэмжээ авагдсан | | | |
| | Хүний тоо | 20451 | 21507 | 105.2 |
| | Мөнгөн дүн /сая.төг/ | 872.4 | 966.4 | 110.8 |

## X. ГАМШГИЙН МЭДЭЭ

| Үйл ажиллагаа | 2022 XII | 2023 XII | 2023/2022 хувь |
|---|---|---|---|
| Нийт ирсэн дуудлага | 84 | 119 | 141.7 |
| Обьектын гал түймрийн | 23 | 26 | 113.0 |
| Хүчтэй салхи шуурга | 4 | 30 | 7.5[1] |
| Усны осол | 0 | 0 | - |
| Төөрсөн сураггүй болсон | 0 | 23 | - |
| Зам тээврийн осол | 5 | 7 | 140.0 |
| Уурхайн осол | 0 | 1 | - |
| Аянга | 0 | 0 | - |
| Малын гоц халдварт | 18 | 24 | 133.3 |
| Газар хөдлөлт | 2 | 3 | 150.0 |
| Дуудлагын үр дүн | | | |
| Аварсан хүн | 8 | 21 | 2.6[1] |
| Аварсан хөрөнгө /сая.төг/ | 1014.5 | 1763 | 173.8 |
| Хохирол /сая.төг/ | 854.6 | 615.7 | 72.0 |
| Иргэд ААН-д хандсан үйл ажиллагаа | | | |
| ААН-ийн хүсэлт | 76 | 998 | 13.1[1] |
| Иргэдийн өргөдөл | 63 | 78 | 123.8 |
| Хяналт шалгалт | | | |
| Хамрагдсан обьект | 174 | 195 | 112.1 |
| Илэрсэн зөрчил | 504 | 328 | 65.1 |
| Газар дээр нь арилгасан | 94 | 125 | 133.0 |
| Албан шаардлага | 81 | 94 | 116.0 |
| Мэдэгдэл | 73 | 84 | 115.1 |
| Торгууль /сая.төг/ | 0 | 0.5 | - |

[1] - дахин их

## XI. ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ БАНКНЫ САЛБАРЫН МЭДЭЭ, сая төгрөгөөр, тоогоор

| Үзүүлэлт | | | Үлдэгдэл | | 2023/2022 хувь |
|---|---|---|---|---|---|
| | | | 2022 XII | 2023 XII | |
| Зээл | **Нийт зээлийн үлдэгдэл** | | **136 163.2** | **171 254.9** | **125.8** |
| | Үүнээс | Анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл | 1 705.7 | 1 297.5 | 76.1 |
| | | Чанаргүй зээлийн үлдэгдэл | 1 454.5 | 1 629.1 | 112.0 |
| Татан төвлөрүүл сэн хөрөнгө | **Нийт харилцахын үлдэгдэл** | | **26 529.3** | **33 545.8** | **126.4** |
| | Үүнээс | Иргэдийн харилцахын үлдэгдэл | 18 043.7 | 22 019.3 | 122.0 |
| | **Нийт хадгаламжийн үлдэгдэл** | | **82 394.0** | **92 990.6** | **112.9** |
| | Үүнээс | Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл | 82 351.0 | 92 949.3 | 112.9 |
| | | Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл | 11 756.7 | 15 526.8 | 132.1 |
| | | Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл | 70 637.3 | 77 463.8 | 109.7 |
| Тоон мэдээлэл | Нийт банкны салбар, нэгжийн тоо | | 34 | 34 | 100.0 |
| | Нийт банкны салбар, нэгжийн ажилтнуудын тоо | | 177 | 166 | 93.8 |
| | Нийт зээлдэгчийн тоо (дансны тоогоор) | | 24 978 | 26 941 | 107.9 |
| | Нийт харилцах данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор) | | 86 729 | 91 522 | 105.5 |
| | Нийт хадгаламжийн данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор) | | 32 061 | 33 507 | 113.7 |
| | Нийт АТМ-ны тоо | | 20 | 18 | 90.0 |
| | Нийт төлбөрийн карт эзэмшигчийн тоо | | 45 557 | 41 364 | 90.8 |

XII.ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН МЭДЭЭ, сая төгрөгөөр

| Үзүүлэлт | мөр | 2022 XII | 2023 XII | | | 23/22 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | төл | гүйц | хувь | хувь |
| **Нийт тэнцвэржүүлсэн орлого /тусламжийн дүн/** | **1** | **70 853.6** | **103 109.9** | **99 921.2** | **96.9** | **141.0** |
| **А.Урсгал орлого** | **2** | **12 678.6** | **18 938.6** | **21 051.6** | **111.2** | **166.0** |
| **I.Татварын орлого** | **3** | **8 849.0** | **11 614.5** | **16 293.6** | **140.3** | **184.1** |
| **1.1 Хүн амын орлогын албан татвар** | **4** | **5 231.9** | **6 862.3** | **11 508.0** | **167.7** | **220.0** |
| 1.1 Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогын татвар | 5 | 5 066.5 | 6 249.0 | 7 020.7 | 112.3 | 138.6 |
| Хувь хүний орлогын албан татварын буцаалт | 6 | - 376.0 | - 406.7 | - 406.7 | 100.0 | 108.2 |
| Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар | | .0 | 450.0 | 4 426.3 | 983.6 | - |
| 1.2 үйл ажиллагааны орлого | 7 | 416.9 | 450.0 | 306.7 | 68.2 | 73.6 |
| 1.3 Хөрөнгө борлуулсаны | 8 | 113.9 | 120.0 | 157.0 | 130.8 | 137.8 |
| 1.5 Бусад татвар | 9 | 10.6 | .0 | 4.0 | - | 37.7 |
| **2.Хөрөнгийн татвар/ҮХХболон буу/** | **10** | **504.6** | **169.6** | **193.7** | **114.2** | **38.4** |
| 3. Авто тээврийн хэрэгслийн | 11 | 999.7 | 320.0 | 347.3 | 108.5 | 34.7 |
| **4. Бусад татвар** | **12** | **2 112.8** | **4 262.6** | **4 244.6** | **99.6** | **200.9** |
| 4.1 Улсын тэмдэгтийн | 13 | 140.1 | 160.0 | 145.3 | 90.8 | 103.7 |
| 4.2 Ашигт малтмал нөөцийн | 14 | 10.6 | 380.0 | 237.6 | 62.5 | 2241.5 |
| 4.3 Газрын төлбөр | 15 | 684.5 | 711.8 | 1 592.4 | 223.7 | 232.6 |
| 4.5 Хог хаягдалын үйлчилгээний | 16 | 170.8 | 243.9 | 158.4 | 64.9 | 92.7 |
| 4.6 Усны төлбөр | 17 | 400.8 | 761.5 | 661.6 | 86.9 | 165.1 |
| 4.7.Малд ногдуулах татвар | 18 | .0 | 1 563.6 | 1 152.0 | 73.7 | - |
| 4.8.Бусад | 19 | 706.0 | 441.8 | 297.3 | 67.3 | 42.1 |
| **II.Татварын бус орлого** | **20** | **3 829.6** | **7 324.1** | **4 758.0** | **65.0** | **101.6** |
| 2.1 Төсөвт байгууллагын өөрийн орлого | 21 | 2 377.8 | 3 153.7 | 2 831.5 | 89.8 | 119.1 |
| 2.2 Бусад нэр заагдаагүй | 22 | 1 451.8 | 4 170.4 | 1 926.5 | 46.2 | 132.7 |
| Б. Хөрөнгийн орлого | 23 | 52.1 | 53.0 | 278.4 | 525.3 | 534.4 |
| **В.Тусламжийн орлого** | **24** | **58 122.9** | **84 118.3** | **78 591.2** | **93.4** | **135.2** |
| 1.Улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг | 25 | 11 786.1 | 16 965.5 | 16 965.5 | 100.0 | 143.9 |
| Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгээс санхүүжих | 27 | 7 875.3 | 11 875.4 | 11 563.0 | 97.4 | 146.8 |
| Төсвөөс санхүүжих | 29 | 31 959.7 | 45 083.3 | 39 868.6 | 88.4 | 124.7 |
| Аймаг нийслэлээс авсан татаас | 30 | 6 501.8 | 7 820.6 | 7 820.6 | 100.0 | 120.3 |
| Сум дүүргээс авсан тэгшитгэл | | .0 | 2 373.5 | 2 373.5 | 100.0 | - |
| **Орон нутгийн төсвийн орлого /тусламжийн орлого ороогүй /** | **31** | **12 730.7** | **18 991.6** | **21 330.0** | **112.3** | **167.5** |
| Улсын төсөвт төвлөрүүлж байгаа орлого | 32 | 2 112.6 | 2 206.0 | 3 102.5 | 140.6 | 146.9 |
| **Аймгийн нийт орлого** | **33** | **14 843.3** | **21 197.6** | **24 432.5** | **115.3** | **164.6** |

## XIII.ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ сар бүрийн эцэст, мянган төгрөгөөр

| Сумд | 2023 I-XII | | | 2023 XII сар | | |
|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөө | гүйцэтгэл | хувь | төлөвлөгөө | гүйцэтгэл | хувь |
| **Дүн** | **14092169.4** | **23238400.3** | **164.9** | **2138079.2** | **10080477.5** | **471.5** |
| Сайнцагаан | 5804354.9 | 13363205.5 | 230.2 | 648030.5 | 8269208.1 | 1276.1 |
| Адаацаг | 302418.0 | 448519.8 | 148.3 | 44678.0 | 59282.6 | 132.7 |
| Баянжаргалан | 478881.4 | 1045722.1 | 218.4 | 75077.5 | 139279.8 | 185.5 |
| Говь-Угтаал | 477600.5 | 413934.4 | 86.7 | 84035.3 | 36058.7 | 42.9 |
| Гурвансайхан | 1524717.5 | 1749320.7 | 114.7 | 488920.6 | 308091.6 | 63.0 |
| Дэлгэрхангай | 541409.6 | 517039.3 | 95.5 | 58539.5 | 70040.7 | 119.6 |
| Дэлгэрцогт | 279125.2 | 343345.8 | 123.0 | 60175.2 | 90986.8 | 151.2 |
| Дэрэн | 389119.4 | 381467.0 | 98.0 | 98679.4 | 76848.3 | 77.9 |
| Луус | 275320.0 | 293621.8 | 106.6 | 39470.0 | 63894.2 | 161.9 |
| Өлзийт | 488665.0 | 1211811.8 | 248.0 | 76910.0 | 323383.8 | 420.5 |
| Өндөршил | 416500.0 | 358054.7 | 86.0 | 34930.0 | 96383.9 | 275.9 |
| Сайхан-Овоо | 288442.4 | 315377.3 | 109.3 | 36252.3 | 49196.7 | 135.7 |
| Хулд | 298090.0 | 337196.7 | 113.1 | 39380.0 | 61626.6 | 156.5 |
| Цагаандэлгэр | 200800.0 | 243114.8 | 121.1 | 31726.0 | 47652.9 | 150.2 |
| Эрдэнэдалай | 1042975.5 | 867667.9 | 83.2 | 127050.5 | 149298.6 | 117.5 |
| Дундговь | 1283750.0 | 1349000.5 | 105.1 | 194224.4 | 239244.2 | 123.2 |

## XIV.ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ДҮН, сар бүрийн эцэст, сая төгрөгөөр

| Зарлагын төрөл | 2022 XII | 2023 XII | | | 2023 XII/ 2022 XII |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | |
| **Нийт зарлага** | **40 987.5** | **67 091.8** | **54 377.4** | **81.0** | **132.7** |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 6 632.7 | 8 596.1 | 8 326.7 | 96.9 | 125.5 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 810.0 | 1 093.9 | 1 021.9 | 96.9 | 126.2 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 5 343.4 | 6 339.7 | 6 185.1 | 93.4 | 115.8 |
| Хангамж бараа материалын зардал | 599.6 | 947.5 | 858.6 | 90.6 | 143.2 |
| Норматив зардал | 86.3 | 112.6 | 111.3 | 98.8 | 129.0 |
| Эд хогшил урсгал засварын зардал | 689.5 | 1 180.2 | 1 106.3 | 93.7 | 160.4 |
| Томилолтын зардал | 190.5 | 354.3 | 321.7 | 90.8 | 168.9 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1 579.3 | 1 482.0 | 1 272.3 | 85.9 | 80.6 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 3 718.4 | 5 619.0 | 4 449.4 | 79.2 | 119.7 |
| Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр | .0 | 2 540.4 | .0 | .0 | - |
| Татаас | 112.0 | 1 495.2 | 1 478.0 | 98.8 | 1 319.6 |
| Засгийн газрын дотоод шилжүүлэг | 8 047.1 | 10 519.9 | 10 452.6 | 99.4 | 129.9 |
| Бусад урсгал шилжүүлэг | 901.9 | 662.7 | 604.2 | 91.2 | 67.0 |
| Хөрөнгийн зардал | 11 186.1 | 23 355.8 | 16 784.4 | 71.9 | 150.0 |
| Эргэж төлөгдөх зээл | 1 090.7 | 2 792.5 | 1 404.9 | 50.3 | 128.8 |

## XV. ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ 12-Р САРЫН ҮНИЙН МЭДЭЭ/аймгаар/

| | Нэр төрөл | Дундговь | Говьсүмбэр | Өмнөговь | Дорноговь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Гурил, дээд зэрэг /Алтантариа/ | 3 438 | 2 850 | 3 181 | 2 766 |
| 2 | Гурил, 1-р зэрэг /Алтантариа/ | 2 882 | 2 715 | 2 726 | 2 550 |
| 3 | Гурил, 2-р зэрэг /Алтантариа/ | 2 063 | 1 625 | 1 960 | 2 000 |
| 4 | Гоймон, /Алтан тариа/, туузан 320 г-тай | 2 166 | 2 083 | 2 182 | 1 982 |
| 5 | Талх, орон нутгийн үйлдвэрийн | 2 397 | 2 641 | 2 511 | 2 797 |
| 6 | Гурилан боов,0.450г, /аймгийн үйлдвэрийн/ | 6 133 | 5 692 | 5 190 | 4 207 |
| 7 | Жигнэмэг /наша марка/150-180г, цайны/ | 2 893 | 1 899 | 2 049 | 1 800 |
| 8 | Цагаан будаа, задгай, кг | 3 953 | 3 780 | 4 315 | 2 729 |
| 9 | Шар будаа, задгай, кг | 3 223 | 3 274 | 3 250 | 2 996 |
| 10 | Хонины мах, кг | 8 500 | 7 246 | 8 830 | 8 991 |
| 11 | Адууны мах, кг | 8 000 | 7 000 | 8 830 | 9 566 |
| 12 | Ямааны мах, кг | 6 500 | 6 000 | 7 489 | 7 489 |
| 13 | Дотор мах, цувдай, цусгүй | 5 000 | 13 038 | 5 000 | 3 000 |
| 14 | Хиам чанасан, 1кг | 14 165 | - | - | 14 779 |
| 15 | Сүү, задгай, л | 5 646 | 5 000 | 5 000 | 4 347 |
| 16 | Сүү савласан,1л. Шимт сүү | 5 378 | 5 349 | 5 427 | 5 398 |
| 17 | Хорхой ааруул, задгай, чихэртэй | 27 279 | 32 404 | 33 247 | 27 928 |
| 18 | Өндөг ,ш,дотоод | 673 | 599 | 620 | 600 |
| 19 | Ургамлын тос, 1литр, Олайна | 9 130 | 9 391 | 10 860 | 5 814 |
| 20 | Өөхөн тос, кг | - | - | 500 | 3 000 |
| 21 | Шар тос, кг | 26 962 | 35 000 | 35 000 | 37 417 |
| 22 | Цөцгийн тос, задгай, кг | 10 125 | 9 492 | 8 055 | 7 920 |
| 23 | Төмс дотоод, кг | 2 114 | 2 449 | 2 022 | 1 662 |
| 24 | Лууван хятад, кг | 2 616 | 2 258 | 3 509 | 3 000 |
| 25 | Байцаа хятад, кг | 2 114 | 2 124 | 2 820 | 2 657 |
| 26 | Сонгино хятад, кг | 2 939 | 4 099 | 3 062 | 3 302 |
| 27 | Элсэн чихэр, кг, орос | 4 668 | 4 449 | 4 681 | 4 554 |
| 28 | Хатуу чихэр, орос, кг, /Барбарис/ | 12 116 | 12 432 | 13 191 | 12 947 |
| 29 | Шоколад, "Alpen gold" | 3 588 | 3 817 | 3 742 | 3 449 |
| 30 | Давс, цагаан, 1 кг, йоджуулсан | 2 940 | 2 970 | 3 727 | 3 011 |
| 31 | Майноз, /Улаанбаатар 500г/ | 7 141 | - | 6 679 | 6 558 |
| 32 | Кетчуп, 900г, Чили Полиш | 3 217 | 4 832 | 3 690 | 2 964 |
| 33 | Ногоон цай, Stimo, савласан 90г | 4 042 | 1 100 | 2 500 | 3 016 |
| 34 | Байхуу цай, Lipton, 20 ширхэгтэй | 4 509 | 4 480 | 4 452 | 4 131 |
| 35 | Цагаан архи, 0.75 ARKHI EXPORT | 28 707 | 26 659 | 28 818 | 26 842 |
| 36 | Пиво, "Cass", 0.5л | 4 262 | 4 149 | 4 094 | 4 099 |
| 37 | Янжуур тамхи, /Esse/, саарал | 3 994 | 3 974 | 3 760 | 3 662 |
| 38 | Янжуур тамхи, /Улаан шонхор/,Монгол тамхи | 2 945 | 2 850 | 2 350 | 2 269 |
| 39 | Бензин, А-80, 1 литр | 2 510 | 2 460 | - | 2 490 |
| 40 | Бензин, А-92, 1 литр | 2 530 | 2 480 | 2 548 | 2 520 |
| 41 | Дизель түлш, 1 литр | 4 000 | 3 980 | 3 965 | 4 020 |

# XVI. ДУНДГОВЬ АЙМГИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

| . | 2023 XII / 2022 XII | 2023 XII / 2023 XI |
|---|---|---|
| **ЕРӨНХИЙ ИНДЭКС** | **106.1** | **100.5** |
| **01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА** | **115.3** | **101.6** |
| 01.1 ХҮНСНИЙ БАРАА | 116.7 | 101.8 |
| 01.1.1 ТАЛХ, ГУРИЛ, БУДАА | 118.8 | 100.8 |
| 01.1.2 МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН | 114.9 | 103.5 |
| 01.1.3 ЗАГАС, ДАЛАЙН БҮТЭЭГДЭХҮҮН | 122.9 | 101.3 |
| 01.1.4 СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ | 131.4 | 105.3 |
| 01.1.5 ТӨРӨЛ БҮРИЙН ӨӨХ, ТОС | 90.9 | 101.1 |
| 01.1.6 ЖИМС, ЖИМСГЭНЭ | 95.3 | 100.2 |
| 01.1.7 ХҮНСНИЙ НОГОО | 117.7 | 101.0 |
| 01.1.8 СААХАР, ЖИМСНИЙ ЧАНАМАЛ, ЗӨГИЙН БАЛ, ЧИХЭР | 113.4 | 100.0 |
| 01.1.9 БЭЛЭН ХООЛ, ХҮНСНИЙ БУСАД БҮТЭЭГДЭХҮҮН | 116.0 | 100.8 |
| 01.2 СОГТУУРУУЛАХ БУС УНДАА | 104.3 | 100.0 |
| **02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС** | **105.8** | **100.1** |
| 02.1 СОГТУУРУУЛАХ УНДАА | 113.3 | 100.3 |
| 02.2 ТАМХИ | 102.5 | 100.0 |
| **03. ХУВЦАС, БӨС БАРАА ГУТАЛ** | **104.6** | **100.3** |
| 03.1 ХУВЦАС, БӨС БАРАА | 104.9 | 100.1 |
| 03.1.1 ХӨВӨН, БӨС БАРАА | 105.7 | 100.0 |
| 03.1.2 БҮХ ТӨРЛИЙН ХУВЦАС | 104.9 | 100.1 |
| 03.1.3 ЖИЖИГ ЭДЛЭЛ, ХЭРЭГСЭЛ | 103.4 | 100.0 |
| 03.2 ГУТАЛ | 104.1 | 100.5 |
| **04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ** | **100.9** | **100.3** |
| 04.1 ОРОН СУУЦНЫ БОДИТ ТҮРЭЭС | 102.3 | 100.0 |
| 04.2 ОРОН СУУЦНЫ ТЕХНИКИЙН БОЛОН ЗАСВАРЫН ҮЙЛЧИЛГЭЭ | 100.6 | 100.0 |
| 04.3 УСАН ХАНГАМЖ БОЛОН ОРОН СУУЦНЫ БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ | 100.0 | 100.0 |
| 04.5 ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ | 101.2 | 100.6 |

| | | |
|---|---|---|
| **05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА** | **105.8** | **100.1** |
| 05.1 ГЭР АХУЙН ТАВИЛГА, ХЭРЭГСЭЛ, ХИВС БОЛОН ШАЛНЫ БУСАД ДЭВСГЭР | 101.6 | 100.0 |
| 05.2 ГЭР АХУЙН ОЁМОЛ, НЭХМЭЛ ЭДЛЭЛ | 121.5 | 100.6 |
| 05.3 ГЭР АХУЙН ЦАХИЛГААН БАРАА | 100.3 | 100.0 |
| 05.4 ГЭР АХУЙН ШИЛЭН ЭДЛЭЛ, САВ СУУЛГА | 101.5 | 100.0 |
| 05.5 ГЭР АХУЙ, ЦЭЦЭРЛЭГИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ХӨДӨЛМӨРИЙН БАГАЖ ХЭРЭГСЭЛ | 110.2 | 100.2 |
| 05.6 ГЭР АХУЙН ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ БОЛОН БУСАД ЖИЖИГ БАРАА ГЭРИЙН БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ | 112.6 | 100.1 |
| **06. ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ** | **107.7** | **100.6** |
| 06.1 ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙНИ ХЭРЭГСЭЛ | 110.7 | 100.9 |
| 06.2 АМБУЛТОРЫН ҮЙЛЧИЛГЭЭ | 100.0 | 100.0 |
| 06.3 ЭМНЭЛЭГТ ХЭВТЭЖ ҮЗҮҮЛСЭН ҮЙЛЧИЛГЭЭ | 100.0 | 100.0 |
| **07. ТЭЭВЭР** | **100.9** | **100.2** |
| 07.1 ТЭЭВРИЙН ХЭРГСЭЛИЙН ХУДАЛДАН АВАЛТ | 103.5 | 100.0 |
| 07.2 ХУВИЙН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭ | 100.2 | 100.4 |
| 07.3 ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ | 100.0 | 100.0 |
| **08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ** | **100.6** | **100.0** |
| 08.2 МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ | 101.7 | 100.0 |
| 08.3 МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭ | 100.0 | 100.0 |
| **09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА ҮЙЛЧИЛГЭЭ** | **109.6** | **100.0** |
| 09.1 ДУУ, ДҮРС, ГЭРЭЛ ЗУРАГ, МЭДЭЭЛЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ | 112.7 | 100.0 |
| 09.2 ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ | 100.0 | 100.0 |
| 09.3 НОМ, СОНИН, БИЧГИЙН ХЭРЭГСЭЛ | 111.5 | 111.5 |
| **10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ** | **100.0** | **100.0** |
| **11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ** | **109.7** | **100.0** |
| 11.1 НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭ | 109.8 | 100.0 |
| 11.2 ЗОЧИД БУУДАЛ ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ | 104.8 | 100.0 |
| **12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ** | **104.2** | **100.2** |
| 12.1 ХУВЬ ХҮНД ХАНДСАН ҮЙЛЧИЛГЭЭ | 104.7 | 100.2 |
| 12.3 ХУВЬ ХҮНИЙ ЭД ЗҮЙЛ, ХЭРЭГЛЭЛ | 100.8 | 100.0 |
| 12.5 ДААТГАЛ | 118.7 | 100.0 |
| 12.6 САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ | 100.0 | 100.0 |

## XVII. ХАА-Н БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН МЭДЭЭ

| | | Хэмжих нэгж | 2022 XII | 2023 он | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | V | VI | VII | VIII | IX | X | XI | XII |
| **1. Малын үнэ /мянган төгрөг/** | | | | | | | | | | | |
| **Тэмээ** | | | | | | | | | | | |
| Нас гүйцсэн | эр | тол | 1,683.3 | 1677.3 | 1695.5 | 1636.4 | 1670.0 | 1760.0 | 1754.5 | 1791.7 | 1922.7 |
| | эм | тол | 1,412.5 | 1409.1 | 1315.0 | 1345.5 | 1385.0 | 1453.0 | 1454.5 | 1527.3 | 1568.2 |
| Өсвөр насны | эр | тол | 1,031.8 | 1016.0 | 995.0 | 990.0 | 972.2 | 1033.3 | 1020.0 | 1022.7 | 1175.0 |
| | эм | тол | 990.9 | 994.4 | 970.0 | 980.0 | 905.6 | 966.7 | 955.0 | 995.5 | 1150.0 |
| **Адуу** | | | | | | | | | | | |
| Нас гүйцсэн | эр | тол | 1,153.60 | 1334.5 | 1322.7 | 1260.0 | 1345.8 | 1358.3 | 1303.8 | 1320.8 | 1362.5 |
| | эм | тол | 1,082.30 | 1226.4 | 1236.4 | 1170.0 | 1204.5 | 1209.1 | 1212.5 | 1241.7 | 1279.2 |
| Өсвөр насны | эр | тол | 819.2 | 825.0 | 845.0 | 850.0 | 872.7 | 911.1 | 964.6 | 873.1 | 900.0 |
| | эм | тол | 788.5 | 816.7 | 830.0 | 835.0 | 865.0 | 875.0 | 896.2 | 845.8 | 863.6 |
| **Үхэр** | | | | | | | | | | | |
| Нас гүйцсэн | эр | тол | 1569.2 | 1685.5 | 1713.6 | 1645.5 | 1620.8 | 1679.2 | 1688.5 | 1850 | 1866.7 |
| | эм | тол | 1319.2 | 1516.4 | 1536.4 | 1472.7 | 1410.0 | 1454.5 | 1445.8 | 1646.2 | 1625.0 |
| Өсвөр насны | эр | тол | 807.7 | 752.0 | 822.7 | 790.0 | 750.0 | 775.0 | 838.5 | 896.2 | 900.0 |
| | эм | тол | 773.1 | 722.0 | 790.9 | 760.0 | 727.3 | 733.3 | 793.3 | 866.9 | 872.7 |
| **Бог мал** | | | | | | | | | | | |
| Нас гүйцсэн хонь | эр | тол | 212.3 | 259.6 | 254.6 | 254.3 | 233.3 | 228.3 | 235.3 | 220 | 228.1 |
| | эм | тол | 146.4 | 178.7 | 172.7 | 175.8 | 160.8 | 159.1 | 161.4 | 150.4 | 147.5 |
| Нас гүйцсэн ямаа | эр | тол | 151.0 | 162.5 | 166.9 | 159.2 | 154.6 | 159.2 | 159.3 | 153.8 | 167.5 |
| | эм | тол | 111.4 | 117.7 | 128.2 | 123.8 | 116.8 | 118.6 | 116.9 | 118.1 | 120.9 |
| **2.Малын гаралтай бүтээгдэхүүний үнэ / мянган төгрөг /** | | | | | | | | | | | |
| Тэмээний ноос | | кг | | 8.0 | 17.0 | | | | | | |
| Ямааны ноолуур | | кг | | 115.0 | 112.0 | 110.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 95.0 |
| Тэмээний шир | | ш | 15.0 | 0 | | | | | | 10 | 20 |
| Адууны шир | | ш | 5.0 | | | | | | | 5 | 10 |
| -2 м-ээс доош хэмжээтэй үхрийн шир | | ш | 8.0 | | | | | | | 5 | 5 |
| -2 м-ээс дээш хэмжээтэй үхрийн шир | | ш | | | | | | | | | |
| Хонины ноостой, өлөн гэдэстэй арьс | | ш | 4.0 | 2.5 | | | 2.5 | 3.0 | 3.0 | 3.5 | 2.0 |
| Ямааны ноолууртай, өлөн арьс | | ш | 35.0 | 35.0 | | | | | 25.0 | 40.0 | 49.0 |

## XVIII. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, оны үнээр, сая төгрөгөөр

| Аж үйлдвэрийн салбар | 2022 XII | 2023 XII | 2023/2022 |
|---|---|---|---|
| **Нийт дүн** | **33 350.6** | **55 785.3** | **167.3%** |
| **Уул уурхай олборлолт** | **25 922.0** | **46 359.2** | **178.8%** |
| Чулуун нүүрс олборлолт | 20 295.6 | 26 432.6 | 130.2% |
| Хүрэн нүүрс олборлолт | 862.4 | 117.2 | 13.6% |
| Чулуу, элс шороо олборлолт | 938.2 | 3 556.9 | 379.1% |
| Дээрх ангилалд ороогүй бусад ашигт малтмалын олборлолт | 3 825.8 | 16 252.5 | 424.8% |
| **Боловсруулах үйлдвэрлэл** | **1 970.4** | **2 031.8** | **103.1%** |
| Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 1 424.1 | 1 560.8 | 109.6% |
| Малын тэжээлийн үйлдвэрлэл | 160.0 | 121.5 | 75.9% |
| Бусад даавуун эдлэл үйлдвэрлэл | 49.9 | 66.2 | 132.7% |
| Үслэг арьсан хувцаснаас бусад хувцас үйлдвэрлэл | 25.4 | 9.7 | 38.2% |
| Нэхмэл болон сүлжмэл хувцас үйлдвэрлэл | 13.9 | .0 | 0.0% |
| Модон, үйсэн, үртсэн болон холтсон бүтээгдэхүүний үйлдвэрлэл | 153.4 | 203.1 | 132.4% |
| Хэвлэх болон хэвлэлийн туслах үйл ажиллагаа | 19.5 | 19.0 | 97.4% |
| Дээр дурдсан ангид ороогүй төмөрлөг бус эрдэс бүтээгдэхүүний бусад үйлдвэрлэл | 124.2 | 51.5 | 41.5% |
| **Цахилгаан, хий, уур, агааржуулалт** | **3 740.0** | **4 807.7** | **128.5%** |
| Уур, агааржуулагчийн хангамжийн үйл ажиллагаа | 3 740.0 | 4 807.7 | 128.5% |
| **Ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа** | **1 718.2** | **2 586.6** | **150.5%** |
| Ус хуримтлуулах, ариутгах, түгээх үйл ажиллагаа | 1 363.2 | 2 162.6 | 158.6% |
| Хог хаягдлыг цуглуулах | 355.0 | 424.0 | 119.4% |

## XIX. ГОЛ НЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ

| Гол нэр төрлийн бүтээгдэхүүн | Хэмжих нэгж | 2022 XII | 2023 XII | 2023/2022 хувь |
|---|---|---|---|---|
| Нүүрс | мян.тн | 374.4 | 467.2 | 124.8 |
| Жонш | мян.тн | 31.1 | 82.5 | 265.3 |
| Гөлтгөнө | мян.тн | 8.5 | 19.0 | 223.5 |
| Дулааны эрчим хүч | мян.гкал | 128.2 | 155.8 | 121.5 |
| Хүснэгт, маягт | х.д.х | 347.4 | 339.6 | 97.8 |
| Талх | тн | 121.1 | 133.9 | 110.6 |
| Нарийн боов | тн | 140.7 | 162.2 | 115.3 |
| Бялуу | тн | 6.3 | 3.3 | 52.4 |
| Чихэр | тн | 3.8 | 2.3 | 60.5 |
| Цэвэр ус | мян.л | 1.3 | 2.7 | 207.7 |
| Архи | мян.л | 16.5 | 8.9 | 53.9 |
| Хэрчсэн гурил | тн | 29.2 | 15.3 | 52.4 |
| Хоормог | мян.л | 0.4 | 0.3 | 75.0 |
| Ааруул | тн | 0.7 | 0.4 | 57.1 |
| Түгээсэн цэвэр ус | мян.т$^3$ | 219.6 | 279.1 | 127.1 |
| Сувагжуулалт | мян.м$^3$ | 147.2 | 186.5 | 126.7 |

Мэдээлэл авах холбоосууд:

http://www.dundgovi.nso.mn/

http://www.1212.mn/

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2024 оны 2 дугаар сарын 15

Дундговь аймгийн Статистикийн хэлтсийн хэлтсийн
дарга Б.Энхтуяа
Утас: (976)-70593777

Дундговь аймгийн Статистикийн

Ахлах мэргэжилтэн Т.Бямбасүрэн
Мэргэжилтэн С.Доржханд
Мэргэжилтэн Н.Давааням
Мэргэжилтэн Г.Ариунжаргал
Утас: (976)-70593715

/StatisticMGL Dundgovi@nso.mn 70593715